



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 05 дугаар сарын 19 өдөр

Дугаар 50

Хэрлэн сум

L ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 50 дугаар хуралдаан 2021 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 15:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 88,4 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Аймгийн Онцгой комиссоос агентлаг, сум, аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтанд өгсөн үүргийн биелэлт танилцуулах,

*Онцгой комиссын гишүүд*

2.Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлт танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

3.Коронавируст халдварын шар түвшинд шилжихтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*



4.Коронавируст халдварын шар түвшинд шилжихтэй холбогдуулан төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг тогтоох талаар хэлэлцэх,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч,  
Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, Онцгой комиссын  
нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга-д:

1.1.Аймгийн Онцгой комисс, Шуурхай штабын хуралдааны шийдвэрийн биелэлтийг Онцгой комисс, Шуурхай штабын дараагийн хуралдаан бүрт танилцуулах,

/  /М.Бадамсүрэн  
/  /Д.Баттулга

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1.Дорнод аймагт вакцины II тунг татах ажилд шаардлагатай шатахууны зардал 1,700,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлэхийг зөвшөөрөв,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг-д:

2.2.Ерөнхий тархвар судлаач эмч батлагдсан тохиолдол бүртгэгдсэн тохиолдолд иргэдийн мэдээллийг аймгийн Цагдаагийн байгууллага, харьяа сумын Засаг даргын Тамгын газарт тухай бүр шуурхай мэдэгдэх,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

2.3.Батлагдсан тохиолдлоор бүртгэгдсэн иргэнтэй тээврийн хэрэгслээр хавьтал болсон Цагдаагийн байгууллагын 2 албан хаагчдыг “Сод” буудал тусгаарлах байранд 7 хоног тусгаарлах,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-д:

2.4.Батлагдсан тохиолдлоор бүртгэгдсэн иргэнтэй тээврийн хэрэгслээр хавьтал болсон Цагдаагийн байгууллагын 2 албан хаагчдын гэр бүлийн гишүүд болон Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн багш нарыг гэрийн тусгаарлалтад авч хяналт тавьж ажиллах,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга-д:

3.1.Коронавируст халдварын шар түвшинд шилжихтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА